



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ ᠡᠳᠢᠶᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠳᠤᠯᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠭᠠ










БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2021/9



БАГАНУУР ДҮҮРЭГ
2021 он

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	14
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2020 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	194 501	45 365	13 151	43 314	55 421	37 250
Үүнээс:						
Тэмээ	205	43	-	160	2	-
Адуу	15 294	4 205	801	3 737	3 539	3 012
Үхэр	18 067	4 687	1 693	4 128	4 289	3 270
Хонь	92 137	21 859	5 970	20 699	27 076	16 533
Ямаа	68 798	14 571	4 687	14 590	20 515	14 435

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX
Суурин хүн ам	тоо	28 787	29 512	29 663	29342	
Төрөлт	тоо	451	503	464	453	432
Нас баралт	тоо	106	108	117	104	123
Шилжиж ирсэн	тоо	590	481	311	889	395
Цэвэр өсөлт	хувь	1.19	1.34	1.17	1.19	1.05'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2021 оны 9 сарын эцэст 102 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 142 (58.2%) хүнээр буурсан байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 4 (3.9%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 205 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 135 (65.9%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 199 иргэн ажилд зуучлуулан орсон ба хувьцаат компанид 9, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 40, төсөвт байгууллагад 107, төрийн бус байгууллагад 8, улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 35 иргэд ажилд орсон байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 25 (25.5%) нь 15-24 насны, 37 (36.3%) нь 25-34 насны залуучууд, 13 (12.7%) нь 35-44 насныхан, 20 (19.6%) нь 45-60 насны, 7 буюу (6.9%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор, IX сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2020 IX	2021 IX	2020 IX	2021 IX
Ажилгүйчүүд, бүгд	244	102	137	58
Үүнээс:				
Дээд боловсролтой	73	34	53	23
Тусгай дунд боловсролтой	15	9	7	4
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	38	7	14	1
Ерөнхий боловсролтой	115	51	63	29
Бага болон боловсролгүй	3	1	-	1

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 34 (33.3%) нь дээд боловсролтой, 14 (8.8%) нь тусгай дунд боловсролтой, 7 (6.9%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 51 (50.0%) нь ерөнхий боловсролтой, 1 (0.9%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 58 (56.9%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 13.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 951.5 (7.5%) сая төгрөгөөр, зарлага 21.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 936.5 (4.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 9.6 (70.1%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 836.0 (6.1%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 885.3 (6.5%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 2.2 (16.1%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 164.4 (1.2%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2020		2021		2021.IX% 2020.IX	2021.I – IX% 2020.I – IX
	IX	I-IX	IX	I-IX		
	сая төгрөг					
Сангийн орлого, бүгд	1 241.7	12 674.7	1 272.4	13 626.2	102.5	107.5
тэтгэврийн сан	827.5	8 454.1	884.7	9 551.8	106.9	113.0
тэтгэмжийн сан	87.2	889.6	92.6	836.0	106.2	94.0
ажилгүйдлийн сан	21.9	221.0	17.4	164.4	79.5	74.4
ҮОМШӨ ¹ -ний сан	106.0	1 077.3	72.1	885.3	68.0	82.2
ЭМД ² -ын сан	199.1	2 032.7	205.6	2 188.7	103.3	107.7
Сангийн зарлага, бүгд	2 352.8	20 120.3	2 444.3	21 056.8	103.9	104.7
тэтгэврийн сан	2 010.5	17 618.2	2 091.8	18 709.2	104.0	106.2
тэтгэмжийн сан	132.9	897.3	174.4	947.5	131.2	105.6
ҮОМШӨ-ний сан	170.8	1 307.1	130.1	1 187.6	76.2	90.9
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	38.6	297.7	48.0	212.5	124.4	71.4

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4593 хүнд 18.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 1795 хүнд 947.5 сая төгрөгийн тэтгэмж, 250 хүнд 1.2 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 130 хүнд 212.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 9 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 1.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.7 (53.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 1.4 (97.4%) тэрбум төгрөг улсын төсвөөс, 30.0 (2.1%) сая төгрөг орон нутгийн төсвөөс,

7.3 (0.5%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 317.2 сая төгрөгийн тэтгэвэр, 387 хүнд 303.8 сая төгрөгийн асаргааны тэтгэмж, 651 ахмад настанд 54.5 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 2974 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 293.1 сая төгрөг, 234 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 253.0 сая төгрөг, 2 хүнд онцгой тохиодлын тэтгэмж 2.4 сая төгрөг, 34 хүнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж 24.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 61 иргэдэд 22.2 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн орлогын бүтэц



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2020		2021		2021. IХ% 2020. IХ	2021. I – IХ% 2020. I – IХ
	IХ	I-IX	IХ	I-IX		
	Сая төгрөг					
Сангийн орлого	314.3	3 096.2	185.6	1 434.3	59.1	46.3
Улсын төсвөөс	314.3	3014.7	184.8	1 397.0	58.8	46.3
Орон нутгийн төсвөөс	-	73.4	-	30.0	-	40.9
Бусад орлого	-	8.1	0.8	7.3	-	90.1
Сангийн зарлага	337.4	2 954.4	89.0	1 289.2	26.4	43.6
Тэтгэвэр	131.2	984.5	-	317.2	-	32.2
Тэтгэмж	33.4	292.1	31.5	303.8	94.3	104.0
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	32.5	208.4	24.0	253.0	73.8	121.4
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	120.4	-	-	-	-
"Алдарт эх" II одонт эхчүүд	0.1	134.0	-	-	-	-
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	-	8.5	-	-	-	-
Насны хишиг	0.1	235.5	-	-	-	-


Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	2.7	22.3	-	-	-	-
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	37.0	218.2	12.9	54.5	34.9	25.0
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	5.6	38.8	3.6	22.2	64.3	57.2
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	72.9	507.5	16.1	293.1	22.1	57.8
Цалинтай ээж	-	61.8	-	-	-	-
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	2.4	58.4	-	-	-	-
ОНО-д түшиглэсэн халамж	-	29.1	0.9	24	-	82.5
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	4.0	-	-	-	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	-	-	2.4	-	-
Бусад үйлчилгээ	19.5	30.9	-	19.0	-	61.5



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 9 сарын байдлаар 447 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 22 (4.6%) буурсан байна. Энэ хугацаанд 111032 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 48172 (30.2%) хүнээр буурч, хэвтэн эмчлүүлсэн 6285 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 190 (3.1%) хүнээр өссөн байна.


Зураг 8. Амбулаторийн үзлэг 2021 оны IX сар




Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 9 сард

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021.I - IX\%}{2020.I - IX}$
Амаржсан эхийн тоо	469	446	95.1
Үүнээс бусад аймгийн харьяат	138	108	78.3
Амьд төрсөн хүүхэд	469	447	95.3
Үүнээс бусад аймгийн харьяат	137	109	79.6
Эхийн эндэгдэл	1	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	4	4	100.0

Зураг 9. Халдварт өвчин, сараар



Зураг 10. Ковид-19, сараар



2021 оны эхний 9 сарын байдлаар халдварт паразит өвчний 107 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 2.2%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 39 (26.7%) тохиолдлоор буурсан байна. Харин цочмог халдварт өвчний 4682 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 97.7%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4605 (59.8 дахин) тохиолдлоор өссөн байна. Тайлант хугацаанд дүүрэгт Ковид-19 өвчний 4644 тохиолдол батлагдсан нь цочмог халдварт өвчний 99.1%-ийг эзэлж байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 1656.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1579.7 продицимиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	146	107	-39
Заг хүйтэн	89	52	-37
Тэмбүү	30	28	-2
Мөөгөнцөр /кандидоз/	4	1	-3
Трихомониаз	19	23	4

Кандилом	3	2	-1
Хламид	1	1	-
Цочмог халдварт өвчин	77	4 682	4 605
Цусан суулга	21	14	-7
Гепатит А	1	2	1
Салхин цэцэг	31	2	-29
Сальмонеллез	4	-	-4
Гар хөл амны өвчин	2	-	-2
Хачигт рикеттиоз	1	-	-1
Скарлатин	3	-	-3
Ковид-19	-	4 644	4 644
Сүрьеэ	11	20	9
Хоолны хордлого	3	-	-3
Нийт халдварт өвчин	203	4 789	4 644



ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд 120 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 (4.3%) хэргээр нэмэгдсэн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 47.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.5 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-IX	2021 I-IX	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	115	120	5	4.3	100.0
Хүний амь нас хохироох	2	-	-2	-100.0	-
Хүний амь нас хохирсон	1	2	1	100.0	1.7
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	56	63	7	12.5	52.5
Бусдын эд хөрөнгө хулгайлах	20	11	-9	-45.0	9.2
Бэлгийн халдашгүй байдал	2	5	3	150.0	4.2
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	1	-	0.8
Дээрэмдэх	1	1	0	-	0.8
Залилан мэхлэх	12	16	4	33.3	13.3
Худал мэдээлэл тархаах	-	1	1	-	0.8
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	8	8	0	-	6.7
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	-	-1	-100.0	-
Мал хулгайлах	4	-	-4	-100.0	-
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах	1	-	-1	-100.0	-
Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах	-	2	2	-	1.7
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	4	3	-1	-25.0	2.5
Автотээврийн хэрэгсэл хууль бусаар авч явах	1	-	-1	-100.0	-

Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	2	2	-	1.7
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	2	2	-	1.7
Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	-	1	1	-	0.8
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	2	2	-	1.7
Автотээврийн хэрэгсэл хулгайлах	2	-	-2	-100.0	-
Хэрэг илрүүлэлтийн хувь		55.9%	47.4%		


Зураг 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 63 (52.5%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 16 (13.3%) нь залилан мэхлэх хэрэг, 11 (9.2%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэргүүд байна.

Тайлант хугацаанд хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших хэрэг 8, бэлгийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 5, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 3, болгоомжгүйгээр хүний амь нас хохироосон, мөрийтэй тоглоом зохион байгуулах, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах, хууль сахиулагчийг эсэргүүцэх, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасан хэргүүд тус бүр 2, гэр бүлийн хүчирхийлэл, дээрэмдэх, худал мэдээлэл тараах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэсэн хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 12. Сogтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний IX сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-IX		2021 I-IX	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	49	25	62	20
Хүний амь нас хохироосон	1	-	-	-
Хүний амь нас хохирсон	-	-	-	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	47	11	49	9
Бэлгийн халдашгүй байдал	1	-	3	1
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	6	3	3
Залилах	-	2	-	-
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	1	1	-
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	3	-	4
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	1	-
Бусдын эд хөрөнгө устгах гэмтээх	-	1	-	-
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	-	-	1
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	2	1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	-	-	3	-
бусад	-	1	-	-
Дүнд эзлэх хувь	42.6	21.7	51.6	16.6

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 62 болж өмнөх оны мөн үеэс 13 (26.5%) хэргээр өссөн бол, гудамж талбайд 20 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 (20.0%) хэргээр буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 51.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.0 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 16.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр буурсан байна.

Зураг 14. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I-IX сар




Хүснэгт 10. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2020 I-IX	2021 I-IX	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	96	83	-13	-13.5
Үүнээс: эмэгтэйчүүд	16	18	2	12.5
хүүхэд	5	0	-5	-100.0
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	116	117	1	0.9
Үүнээс: нас барсан	4	2	-2	-50.0
гэмтсэн	61	69	8	13.1
Саатуулагдсан хүний тоо	450	326	-124	-27.6
Баривчлагдсан хүний тоо	129	131	2	1.6
Учирсан хохирол /сая төгрөг/	140.8	231.7	90.9	64.6
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	92.4	38.1	-54.3	-58.8

Тайлант хугацаанд 117 хүн гэмт хэргийн улмаас хохирсон ба үүнээс 69 хүн гэмтэж, 2 хүн нас барсныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмтсэн хүн 8 (13.1%) хүнээр өссөн бол, нас барсан хүн 2 (50.0%) хүнээр буурсан байна. Мөн 326 хүн саатуулагдаж, 131 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс саатуулагдсан хүний тоо 124 (27.6%) хүнээр буурч, баривчлагдсан хүний тоо 2 (1.6%) хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 15. Гэмт хэрэгт холбогдсон иргэд, хувиар, 2021 I-IX сар



Гэмт хэргийн улмаас 231.7 сая төгрөгийн хохирол учирсны 88.3 (38.1%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




ҮНЭ ХАНШ

2021 оны 9 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2021 оны 9 сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 700	1 700		1 700
	I зэрэг	кг	1 400	1 400		1 400
	II зэрэг	кг	1 050	1 000		1 050
Будаа	цагаан	кг	2 400	2 400		2 400
	шар	кг	2 050	2 100		3 000
Хонины мах	ястай	кг			13 000	
	цул	кг			14 000	
Үхрийн мах	ястай	кг			14 000	
	цул	кг			14 500	
Адууны мах, ястай		кг			10 000	
Ямааны мах		кг			10 000	
Элсэн чихэр		кг	2 250	2 300		2 325
Сүү /задгай/		л	1 350			
Тараг /задгай/		л	1 575			
Цэцгийн тос, Орос		кг	5 000	4 750		4 750
Байцаа		кг			1 700	
Манжин		кг			2 250	
Төмс	монгол	кг			1 000	
Лууван	монгол	кг			3 250	
Сонгино	хятад	кг			2 250	
	монгол	кг			2 750	
Сармис, булцуу		ш			700	
Огурцы, хятад		кг			8 125	
Помидор, хятад /үрлэн/		кг			8 125	
Ургамлын тос/ siesta/		ш	6 825	6 825		6 825
Өндөг		ш	400	400		400
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	2 000	2 000	2 000
		Дунд 700 гр	ш	1 800	1 800	1 800
		жижиг 500 гр	ш	1 500	1 500	1 500
	Атар талх		ш	1 200	1 200	1 200

Зураг 16. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 9-р сард



Зураг 17. Нэг кг махны дундаж үнэ, жил бүрийн 9-р сард



Хүснэгт 12. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

	2018 IX	2019 IX	2020 IX	2021 IX
	төгрөг			
Адууны шир	10 000	7 500	7 500	7 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	8 000	3 000	3 000	4 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	13 000	10 000	8 500	8 000
Хонины арьс	2 000	2 000	2 000	1 500

Хүснэгт 13. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2017 IX	2018 IX	2019 IX	2020 IX	2021 IX	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 480	1 648	1 810	1 450	2 040	590	40.7
АИ -92	1 630	1 840	1 860	1 470	2 070	600	40.8
Дизель түлш	1 720	2 170	2 390	2 180	2 550	370	17.0

2021 оны 9 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 600 (40.8%) төгрөгөөр өссөн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2021 оны эхний 9 сарын байдлаар 103.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9.1 (9.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 14. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020}$ %	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020}$ %
Нүүрс олборлолт	м.тн	2 690.3	2 950.8	109.7	90 125.1	98 852.5	109.7
Дулаан дамжуулалт	м.гкал	101.3	102.1	100.8	3 418.7	3 543.8	103.7
Талх үйлдвэрлэлт	тн	152.9	170.9	111.8	215.2	251.2	116.7
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	33.5	41.0	122.4	273.9	390.2	142.5
Зайлуулсан хог хаягдал	м.м3	36.0	42.5	118.1	372.6	432.4	116.0
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					94 405.5	103 470.1	109.6


Зураг 18. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Оны эхний 9 сарын байдлаар нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 260.5 (9.7%) мянган тонн, үнийн дүнгээр 8.7 (9.7%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 0.8 (0.8%) мянган гкал-аар, үнийн дүнгээр 125.1 (3.7%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 18.0 (11.8%) тонноор, үнийн дүнгээр 36.0 (16.7%) сая төгрөгөөр, нарийн боовны үйлдвэрлэлт 7.5 (22.4%) тонноор буюу 116.3 (42.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд 42.5 мянган м3 хог зайлуулсан нь өнгөрсөн оноос 6.5 (18.1%) мянган м3-аар нэмэгджээ.

Зураг 19. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 20. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн IX сард




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1616.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 117.1 (7.8%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 853.3 (52.8%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 15. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	1 499.7	1 616.8	117.1
Орон сууц	275.3	298.7	23.4
Ус борлуулалт, бүгд	581.9	690.7	108.8
Хүн амд	349.1	363.1	14.0
Аж ахуйн нэгжид	232.8	327.6	94.8
Сувагжуулалт	553.5	559.0	5.5
Бусад	89.0	68.4	-20.6

Зураг 21. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 16. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	425 978.9	358 237.5	84.1
Тавлаг өргөө	74 254.5	58 642.4	79.0
Маргад өргөө	79 144.7	59 048.5	74.6
Сод хөгжил	96 524.1	92 582.3	95.9
Шинэ элч	77 361.0	66 978.5	86.6
Уурхайчин	52 445.4	43 595.1	83.1
Содон суварга	46 249.2	37 390.7	80.8

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2021 оны 10 дугаар сарын 13

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ 

Валютын ханш 



©2017


аппликейшнаас

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ аваарай

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn